



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2026 оны 06 сарын 03 өдөр

Дугаар А/402

Булган сум

Гүйцэтгэгчтэй гэрээ шууд байгуулах
эрх олгох тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.4 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.1.4 дэх заалт, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн XII/90 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтын 1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Булган аймаг Сэлэнгэ сумын Төрийн албан хаагчийн орон сууцны барилга угсралтын нэмэлт хөрөнгө оруулалт 36,000,000 (гучин зургаан сая) төгрөгөөр “Тийм Эттэ” ХХК-тай гэрээ байгуулах эрхийг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Ү.Бямбасүрэн)-т олгосугай.

2. Гэрээнд заагдсан ажлыг тогтоосон хугацаанд чанартай гүйцэтгэн хүлээлгэн өгөхийг “Тийм Эттэ” ХХК-ийн захирал (Х.Баттулга)-д даалгасугай.

3. Булган аймаг Сэлэнгэ сумын Төрийн албан хаагчийн орон сууцны барилгын угсралтын нэмэлт ажилд хяналт тавьж ажиллахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Ү.Бямбасүрэн)-т даалгасугай.

4. Сэлэнгэ сумын Төрийн албан хаагчийн орон сууцны барилгын угсралтын дутуу ажлыг Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн XII/90 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтын 1.1 дэх заалтад тусгагдсан төсөл арга хэмжээнээс санхүүжүүлэхийг Байгаль хамгаалах сангийн нягтлан бодогч (Б.Очирсүрэн)-д даалгасугай.

5. Тус хөрөнгийг холбогдох хууль, журам, гэрээний дагуу хүлээн авч данс бүртгэлд бүртгэж хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалтад хяналт тавьж ажиллахыг Сэлэнгэ сумын Засаг дарга (А.Ганбагана)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Д.ПҮРӨВ-ОЧИР

